

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 14 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны аравдугаар сарын 10-ны 10 цаг 32 минутад эхэлж, 12 цаг 35 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 2 цаг 03 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Биеийн тамир, спортын газрын дарга, Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг дүнгийн тухай.	Биеийн тамир, спортын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Мяхандорж овогтой Наранбаатар 77,8 оноогоор тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тул төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэж, нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв. Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Зоригтболд овогтой Солонго 77,8 оноогоор, Мягмарсүрэн овогтой Халиун 63,9 оноогоор тус тус тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тул төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэж, ажлын байрны шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа З.Солонгыг Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв.
2	Боловсрол, соёл урлагийн газрын Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоог нөөцөөс нөхөх тухай	Боловсрол, соёл, урлагийн газрын Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 136 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Цэдэвдамба овогтой Отгонжаргалыг нэр дэвшүүлэв.
3	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд мэргэшлийн шалгалт зарлах тухай	Тус аймгийн нутгийн захиргааны зарим байгууллагаас ирсэн төрийн захиргааны албан тушаалын дэс түшмэлийн 6, туслах түшмэлийн 4 нийт 10 сул орон тооны захиалгыг төрийн албаны төрийн албаны мэргэшлийн шалгалт зарлуулахаар шийдвэрлэж, ТАЗ-д хүргүүлэхээр болов.
4	Дэлгэрцогт, Дэлгэрхангай сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зарлах тухай.	Дэлгэрцогт, Дэлгэрхангай сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын бүртгэл 2017 оны 11 сарын 06-нд 09.00–12.00, 13.00-17.00 цагт, шалгалтыг 11 сарын 07-08-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэж, холбогдох арга хэмжээ авахыг ажлын албанд үүрэг болгов.
5	Л.Уранбилэгийг томилохоос татгалсан Эрдэнэдалай сумын ИТХ-д хариу хүргүүлэх тухай	Л.Уранбилэгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар яаралтай хянуулан томилох эсэх талаар хууль зүйн үндэслэлтэй хариу ирүүлэх чиглэл хүргүүлэхээр шийдвэрлэв.
6	Б.Туулын өргөдлийг хянан шийдвэрлэх комисс томилох ажиллуулах	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтнээр ажиллаж байсан Б.Туулын гомдлыг хянан шийдвэрлэх комиссыг дарга: А.Лхагвасүрэн /Салбар зөвлөлийн гишүүн, Шүүхийн Тамгын газрын дарга/ гишүүдэд А.Нарантуяа /Салбар зөвлөлийн гишүүн, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга/, М.Ганбаатар /Салбар зөвлөлийн гишүүн, Цагдаагийн газрын дарга / нарын бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулахаар болов.